# ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НЭР

Б.Батболд
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага,
стратегийн профессорын багийн
профессор, хурандаа

***Товч агуулга:*** Дэлхийн улс орнууд нь ард иргэдийнхээ боловсролыг нэн тэргүүнд тавьж, тухайн улсын их, дээд сургууль нь олон улсад хүлээн зөвшөөрөгдөх байдал нь хамгаас чухал байр суурийг эзлээд байна.

Дотоод хэргийн их сургууль нь төрийн тусгай албаны албан хаагчдыг бэлтгэн гаргадаг онцлог, чиг үүрэг, түүхэн замнал, эрх зүйн орчин, хуулийн этгээдийн нэршлийг судалж, дүн шинжилгээ хийсэн.

Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын хүний нөөцийг бэлтгэж, захиалагч байгууллагад нийлүүлэн, тухайн байгууллагын захиалгад болон олон улсад хүлээн зөвшөөрөгдөх мэргэжил, мэргэжилтэн, эрх зүйн орчин, төрийн бодлогын уялдаа холбоо нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийж, ярилцага болон санал асуулга явуулж, тандан судлах судалгаа хийж, дүн шинжилгээ хийн, санал гаргана.

***Түлхүүр үгс:*** Хууль зүй, дотоод хэргийн их сургууль, сургалтын үйл ажиллагаа, эрх зүйн орчин, хуулийн этгээдийн нэр.

## Оршил

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 229 дүгээр тогтоолоор Хууль зүй, дотоод хэрэг, тагнуулын салбарын боловсон хүчин бэлтгэх, давтан сургах тогтолцоог боловсронгуй болгох, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын уялдааг сайжруулах зорилгоор Цагдаагийн академи, Үндэсний тагнуулын академи, Хилийн цэргийн дээд сургуулийг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяанд Дотоод хэргийн их сургуулийг байгуулсан[1].

2012 оноос хууль зүйн салбарын шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 87 дугаар тогтоолоор Дотоод хэргийн их сургуулийг Хууль сахиулахын их сургууль болгон өөрчлөн зохион байгуулсан[2].

Гэтэл Монгол Улсын Их Хурлын 2016 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 26 дугаар тогтоолоор Хууль сахиулах ажиллагааны тухай хуулийг хууль санаачлагчид нь буцаасан байдаг[3].

2019 онд Дотоод хэргийн их сургуулиас Хууль зүй, дотоод хэргийн яаманд санал хүргүүлж, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 152 дугаар тогтоолоор Хууль сахиулахын их сургуулийг Дотоод хэргийн их сургууль өөрчлөн зохион байгуулсан[4].

[1]Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем https://www.legalinfo.mn/law/details/2372?lawid=2372
[2]Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем https://www.legalinfo.mn/law/details/8763?lawid=8763
[3]Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем https://www.legalinfo.mn/law/details/12099?lawid=12099
[4]Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем https://www.legalinfo.mn/law/details/14309?lawid=14309

Сүүлийн 10 жилийн дотор Дотоод хэргийн их сургуулийн хуулийн этгээдийн нэр, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, сургалтын үйл ажиллагаа, мэргэжлийн индекс ойр ойрхон өөрчлөгдөж байгаа шалтгаан нөхцөлийг судалж үзэх шаардлагатай гэж үзлээ.

Иймд Монгол улсын төрийн байгууллагуудын нийтлэг нэр, их сургуулийн эрх зүйн орчин, боловсролын индекс, хуулийн этгээдийн нэршлийг тодорхойлж, санал дэвшүүлэхээр зорилоо.

**Судлагдсан байдлын тойм:** Тойм судалгааг хийхдээ сэдвийн хүрээнд Дотоод хэргийн их сургуулийн удирдлага, эрдэмтэн багш, судлаачид нарын хуримтлуулсан мэдлэг, туршлагаас болон сонсогч, суралцагч нараас мэдээлэл авч, захиалга байгууллагын удиирдлагуудтай ярилцлагын аргаар болон тандан судлах судлагаа хийн, түүн дээр дүн шинжилгээ хийж, цаашид их сургуулийнхаа хуулийн этгээд нэршлийг тодорхойлох, эрх зүйн орчинг боловсронгуй болгох арга замыг эрэлхийлэхийг зорилго болголоо.

Дотоод хэргийн их сургуулийн туухэн замналын хувьд БНМАУ-ын Ардын Сайд нарын зөвлөлийн /хуучин нэрээр/ 1933 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 8 дугаар тогтоолоор Дотоодыг хамгаалах газрын дунд сургууль байгуулж байжээ. 1934 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр Дотоодыг хамгаалах газрын даргын 687 дугаар тушаалаар сургуулийн захирлыг томилон орон тоог баталсанаар “Төв сургууль” байгуулагдсан түүхтэй бөгөөд өнөөдрийг хүртлэх хугацаанд нийт 13 удаа өөрчлөн зохион байгуулагдсан[5].

Доктор, профессор Б.Бат-Эрдэнэ, Ж.Эрдэнэбулган нар их сургуулийн бие даасан байдлыг хангах, түүний өвөрмөц тогтолцоо нь, уламжлал, үнэт зүйл, профессор багш, тэргүүлэх эрдэмтдийн үйл ажиллагааг улс төр, нийгэм, эдийн засгийн сөрөг хүчин зүйлээс хамгаалах гол дархлаа болж байгаагаараа онцлог байна гэж тэмдэглэсэн байдаг[6].

Түүнчлэн гадаадын их, дээд сургуулиудын болон Дотоод хэргийн их сургуулийн үүсэл хөгжил, түүхэн замнал, өнөөгийн байдал, сургалтын үйл ажиллагаа, мэргэжлийн индекс, практик байгууллагад тусгалаа олж байгаа хэлбэр зэргийг судалж үзлээ.

Хүнийг сургах гэдэг нь эртний Педагогик /pedagogy/ буюу сургалт гэдэг нь грек гаралтай үг бөгөөд “пайдос” - хүүхэд, “аго” - дагуулж явах, шууд утгаараа хүүхдийг дагуулж явах гэсэн утгатай [7] . Эртний Грекд эзнийхээ хүүхдийг сургуульруу дагуулж явж байгаа боолыг ийнхүү нэрлэдэг байсан бөгөөд, сургуульд нь өөр нэг боол-эрдэмтэн хичээл заадаг байсан байна. Цаг хугацаа өнгөрсөөр энэхүү ойлголт нь *"хүүхдийг амьдралд хөтлөх"* болж хувьсан өөрчлөгджээ. Харин XIX зууны сүүл үе XX зууны эхэн үеэс сургалт нь зөвхөн хүүхдэд гэлтгүй насанд хүрсэн хүнд ч хэрэгтэйг тодорхойлсон олон онол урсгалууд үүсэн хөгжиж ирсэн.

Сургалтын үйл ажиллагааны түүхэн хөгжлийг авч үзвэл анхны сургуулиуд Эртний Египет, Грек, Ромд байгуулагдаж, Александрийскийн их сургууль нэртэйгээр манай эрний V зуунд археологчид хамгийн анхны их сургууль байгуулж, тухайн сургууль нь 13 лекцийн танхимтай, 5000 гаруй суралцагчдыг

[5]Дотоод хэргийн их сургуулийн вэб сайтаас
http://wwwJeu.gov.mn/page/853.shtml?seM 584&subsel=1606
[6] Б.Бат-Эрдэнэ, Ж.Эрдэнэбулган. Дээд боловсролын засаглал эрх зүйн асуудал, шийдэл.
[7]https://dic.academic.ru/dic.nsf/ruwiki/19903

багтаах боломжтой байжээ[8]. Өнөөдрийг хүртэл үйл ажиллагаагаа явуулж байгаа эртний их сургуулийн талаар эрдэмтэд тодорхойлохдоо 859 онд Мароккод байгуулагдсан Каруаны их сургууль буюу зарим судлаас энэ нь их сургууль бус исламын шашины төв байсан гэж үздэг нь их сургуулийн үүсэл хөгжлийн түүх өнөөг хүртэл маргаантай хэвээр байгааг харуулж байна. Европ тивд анхны их сургуулиуд Италийн Болони хотод, 1200 онд Парисийн их сургууль, 1209 онд алдарт Кембрижийн их сургууль, 1348 онд Прагийн их сургууль, 1365 онд Чехийн их сургууль байгуулагдсан нь их сургууль улс орны хөгжлийн хандлагыг чиглүүлдэг онолын үүднээс авч үзвэл Европ тивийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулсан байдаг.

Дотоод хэргийн их сургууль нь 1934 оноос хойш өнөөдрийг хүртэл төрийн тусгай албаны албан хаагчдыг бэлтгэж ирсэн Монгол Улсын дээд боловсролын тогтолцоонд баттай байр суурийг эзэлсэн Монгол Улсын үндэсний ууган сургуулиудын нэг бөгөөд их сургуулийн түүхэн 88 жилийн ой энэ жил тохиож байна.

Дотоод хэргийн их сургуулийн түүхэн хөгжил дэлхийн бусад орны их сургуулиудтай харьцуулбал ихээхэн залуу хэдий ч Монгол Улсад байгуулагдсан 2 дахь их сургууль гэдгээр нийт ажиллаж байгаа эрдэмтэн, багш, судлаач, сурч байгаа сонсогч суралцагчид, үе үеийн төгсөгчид маань төрөлх сургуулиараа бахархах нь зүйтэй юм.

Манай сургууль хөгжлийнхөө түүхэн хугацаанд нийгмийг аюулаас хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах, хууль зүй, дотоод хэргийн салбарын дээд боловсролтой эрх зүйч, команд-улс төрийн ажилтан мэргэжлүүдээр нийт 20 мянга гаруй, мөн 40 мянга орчим мэргэжлийн албан хаагчдыг бэлтгэж, эдгээр мянга мянган төгсөгчид маань эх орныхоо өнцөг булан бүрд тушаал өвөртлөн ажиллаж, нэр хүндтэй, хариуцлагатай үйлс болох гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, улсын хил хамгаалах, хорих байгууллагын аюулгүй байдал, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, шинжлэн магадлах, гамшгаас урьдчилан сэргийлэх, авран хамгаалах ажиллагааг нэр төртэй гардан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дотоод хэргийн их сургууль нь Монгол Улсын Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагууд болох Цагдаагийн.Хил хамгаалах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Онцгой байдлын, Шүүхийн шинжилгээний байгууллагуудын болон Дотоод цэргийн мэргэшсэн хүний нөөцийг Боловсролын тухай, Дээд боловсролын тухай хууль тогтоомжийн хүрээнд бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэхээс гадна судалгааны ажил зонхилсон лаборатори бүхий эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн нэгдэл хэлбэртэй дээд боловсролын сургалтын байгууллага бөгөөд шүүх эрх мэдлийн байгууллага, Архив, Улсын бүртгэл, Гадаадын иргэн, харьяат, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг, Гааль, Татвар, Нийгмийн даатгалын болон бусад төрийн байгууллага болон их дээд сургуулийн багш, судлаач, албан хаагчдыг магистр, докторын зэргийн сургалтад хамруулж, удирдах ажилтан болон судлаач мэргэжилтэн бэлтгэдгээрээ онцлогтой.

Сүүлийн жилүүдэд судлаачид их сургуулийн бие даасан байдлыг хангах зайлшгүй шаардлагатайг онцолж байгаа бөгөөд тусгай хууль тогтоомжоор төрийн

[8]http://vladhistory.com/istoriya-poyavleniya-pervyx-shl<ol/
http://www.para.by/articles/text/samyi-pervyi-universitet

өмчийн их сургуулиудад нийтийн статус олгох, эрх тэгш хөгжих боломжоор хангах асуудлыг хөндсөөр байна.

Их сургуулийн эрх зүйн байдлыг тусгайлсан хуулиар зохицуулах боломж, жишиг байгаа эсэхийг судлан ОХУ-ын нийслэл Москва хот, хойд нийслэл гэж нэрлэгддэг Санкт-Петербург хотод байрлах нэр бүхий сургуулиуд болох М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн их сургууль, Санкт-Петербургийн их сургуулийн эрх зүйн байдал нь “М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн их сургууль болон Санкт-Петербургийн их сургуулийн” тухай Холбооны хуулиар зохицуулагддаг[9] . Тухайн хуулийн 1 дүгээр зүйлд энэхүү хуулиар Оросын Холбооны Улсын тэргүүлэх, классик сургуулиуд болох М.В.Ломоносовын нэрэмжит Москвагийн их сургууль, Санкт-Петербургийн их сургуулийн эрх зүйн байдлыг тодорхойлно гэж заасан байдаг.

Гэхдээ эдгээр сургуулиуд нь 200-290 жилийн өмнө үүсгэн байгуулагдсан арвин туршлагатай өөрийн гэсэн судалгааны чиглэл тогтсон сургуулиуд болохыг онцлох нь зүйтэй.

Орчин үеийн сургуулиуд дунд ч мөн өөрийн гэсэн салбар хуультай сургуулиуд ч байдаг байна. Үүний тод жишээ нь Бүгд Найрамдах Казахстан улс юм. Эрх зүйн тогтолцооны хувьд хурдацтай хөгжиж байгаа Бүгд Найрамдах Казахстан Улсын хувьд ч их сургуулийн эрх зүйн статусыг тодорхойлсон хуультай болох асуудалд анхаар “Назарбаевын их сургууль”-ийн эрх зүйн байдлыг тодорхойлсон Бүгд Найрамдах Казахстан Улсын “Назарбаев их сургууль, Назарбаев сэтгэн бодох сургууль, Назарбаев сан”-гийн тухай хуулийг 2010 онд баталсан байдаг[10].

Үүнээс гадна эдийн засгийн хөгжингүй улсууд ч их сургуульд зориулсан тусгайлсан хуулиуд баталдаг жишиг байна. Жишээлбэл, Өмнөд Солонгос Улсад “Сөүлийн үндэсний их сургуулийн тухай” хууль (2014), “Улсаны шинжлэх ухаан, технологийн үндэсний институтийн тухай” хууль (2013), Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад “Шпэерийн захиргааны шинжлэх ухааны их сургуулийн тухай" Райланд-Пфальц мужийн хууль (2010) юм.

Монгол Улсад Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа 12 агентлаг, байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж байна. Өөрөөр хэлбэл Цагдаагийн, Хил хамгаалах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Архивын, Гадаадын иргэн, харьяатын, Улсын бүртгэлийн, Оюуны өмчийн, Дотоод хэргийн их сургууль, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хууль зүйн туслалцааны төв, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг гэсэн байгууллагууд байна.

Дотоод хэргийн их сургуулийн хувьд байгууллагын статустай хэдий ч Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагуудын албан хаагчдыг бэлтгэн гаргаж байгаа бөгөөд Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль гэх мэт хууль тогтоомжуудыг удирдлага болгон ажиллаж байгаа юм. Харин хүний нөөцийн захиалгачбайгууллагуудын үйл ажиллагаа нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль болон салбарын эрх зүйн баримт бичгээр зохицуулагдаж байна.

[9]https://rg. ru/2009/11/13/universitety-dok.html
[10]https://online.zakon.kz/Document/?doc_id=30914968#pos=1;-65

Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлагуудын удирдлагыг Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18[3] дугаар зүйлд заасны дагуу Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газар 6 жилийн хугацаагаар томилж, чөлөөлдөг бөгөөд Дотоод хэргийн их сургуулийн хувьд статусаас хамааран нарийвчилсан зохицуулалт одоогоор байхгүй байгаа нь учир дутагдалтай юм.

Дотоод хэргийн их сургуулийн хувьд батлагдсан бүтэц, орон тооны дээд хязгаарыг бусад төрийн байгууллагатай харьцуулбал хамрах хүрээ их, албан хаагчийн орон тооны дээд хязгаараас илүү байгаагаас үзвэл төрийн тусгай чиг үүрэг бүхий албан хаагч, хүний нөөцийг бэлтгэн гаргадаг онцлогыг харгалзан үзэж цаашид тус их сургууль нь бие даасан эрх зүйн зохицуулалттай байж болох зайлшгүй хэрэгцээ, шаардлага үүссэн байж болох талтай.

Өөрөөр хэлбэр Дотоод хэргийн их сургуулийг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа байгууллага болгох хэрэгцээ, шаардлага бий болсон үзэж байна.

Хэрэв Дотоод хэргийн их сургууль нь бие даасан эрх зүйн зохицуулалттай болвол Монгол Улсын Засгийн газар өөрчлөгдөх, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн солигдсон ч Их сургуулийн албан хаагчид нь Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх зүйн баталгаагаар хангагдана гэж үзэж байна.

Түүнчлэн Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэгт заасан *“Тухайн байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдолд энэ хуулийн 23.3-т заасан тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахыг хориглоно"*[11] гэсэн хууль зохицуулалт үйлчлэх юм. Энэ хуулийн заалт нь одоогоор хэрэгжих эрх зүйн үндэслэл бүрдээгүйгээс үүдэн Хууль зүй, дотоод хэргийн сайд солигдох бүрд Дотоод хэргийн их сургуулийн захирлыг солих, шинээр томилох, их сургуулийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлт орж, улмаас их сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаа болон сургалтын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөнө гэж үзэхээр байна.

Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны мөрийн хөтөлбөрт хууль зүйн салбарын шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 87 дугаар тогтоолоор Дотоод хэргийн их сургуулийг нэрийг Хууль сахиулахын их сургууль болгон өөрчлөн зохион байгуулж,[1] [12] Засгийн газрын мөрийн хөтөлбөрт “Хууль сахиулах ажиллагааны тухай хууль”-ийг шинээр боловсруулж, батлуулахаар туссан бөгөөд Монгол Улсын Их Хурлаас “Хууль сахиулах ажиллагааны тухай хууль”-ийг батлаагүй байхад Дотоод хэргийн их сургуулийн нэрийг Хууль сахиулах их сургууль болгон өөрчилж, улмаар мэргэжлийн индекс, нэршлийг “хууль сахиулагч” гэж өөрчилсөн нь цаг үеэ олоогүй шийдвэр байсан гэж үзнэ.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 26 дугаар тогтоолоор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 53 дугаар зүйлд заасан журмын дагуу Улсын Их Хурлын эцсийн найруулгатай танилцах, ёсчлох, Монгол Улсын Ерөнхийлөгчид илгээх, “Төрийн

[11] https://legalinfo.mn/mn/detail?lawId=13025
[12]Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем https://www.legalinfo.mn/law/details/8763?lawid=8763

мэдээлэл” эмхэтгэлд хэвлэн нийтлэх ажиллагаанууд хийгдээгүй үндэслэлээр Хууль сахиулах ажиллагааны тухай хууль болон бусад хуулиудыг хууль санаачлагчид нь буцаасан байдаг[13] .

Дээр дурдсан Монгол Улсын Засгийн газраас гаргасан эрх зүйн актуудыг судалж үзвэл Монгол Улсын Засгийн газар өөрчлөгдөх болгонд тус их сургуулийн хуулийн этгээдийн нэршил өөрчлөгдөх, түүнчлэн Их сургуулийн дүрэм, бүтэц, орон тооны хязгаар, албан хэрэг хөтлөлтөд өөрчлөлт орж, улмаар боловсролын индекст өөрчлөлт орох, сургалтын хөтөлбөрт өөрчлөлт орох, цаашлаад сонсогч, суралцагчдын сурлагад хүртэл нөлөөлөхөөр байна.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 4.2 дугаар зүйлийн Тайлбарт: *“Энэ хуульд заасан “хууль сахиулагч" гэж цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх. төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд, байгаль хамгаалагчийг ойлгоно"*[14] гэж 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан байна. Гэтэл Хил хамгаалах, Онцгой байдлын болон Шүүхийн шинжилгээний байгууллагад ажиллаж байгаа албан хаагчид хамаарахгүйг ойлгоно.

**Дүгнэлт**

1 .Сургуулийн нэр /Хуулийн этгээд/ өөрчлөгдсөнөөр сургалтын хөтөлбөрийн индекст өөрчлөлт орж үл ойлголцол үүсэх магадлалтай. Жишээ татвал, 2012 онд Дотоод хэргийн их сургуулийн нэрийг Хууль сахиулахын их сургууль болгон өөрчилснөөр “Цагдаа-хууль сахиулах ажил”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх-хууль сахиулах ажил” гэх сургалтын хөтөлбөрүүдийг батлуулсан байдаг. Мэдээж үзэл бодлын хувьд цагдаагийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллах мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх нь зөв юм. Гэтэл шилжилтийн хөтөлбөр гэж нэрлэгдсэн хөтөлбөрөөр суралцаж судлах ёстой байсан хичээлээ судалдаггүй, эсхүл бүрэн хамрагдаж чаддаггүй гэх мэт зүйлүүд урган гарч иржээ.

Түүнчлэн, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх-хууль сахиулах ажил” мэргэжлээр төгссөн төгсөгчид бусад их дээд сургууль, гадаадын их дээд сургуулийн магистрантурт элсэн суралцах боломжгүй бөгөөд хууль сахиулах гэх мэргэжил нь тухайн сургуулиудын тавигдах шаардлагад тохирдоггүй байдал ажиглагдсаар байна. Гадаад оронд ийм жишиг байгаа эсэхийг судлан үзвэл ОХУ-ын ДХЯ-ны сургуулийн төгсөгчид “Правоохранительнаядеятельность” буюу “хууль сахиулах” гэх мэргэшлээр төгсдөг хэдий ч үндсэн мэргэжлийн чиглэл нь эрх зүй байдаг онцлогтой байна.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн хэрэгжүүлж байгаа “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх-хууль сахиулах” хөтөлбөрөөр суралцаж төгссөн төгсөгчдөд захиалагч байгууллагын зохих албан тушаалд ажиллахад ажлын байрны тодорхойлолтод заасан тавигдах шаардлагад нийцдэггүй. Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, газар, нэгжид ажиллах ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчийн ажлын байрны тодорхойлолтод эрх зүйч байхаар, хорих байгууллагын харуул хамгаалалт, аюулгүй байдлын чиг үүрэг бүхий алба хаагчдын ажлын байрын тодорхойлолтод эрх зүйч байхаар тус тус заасан байдаг. Энэ нь сургалт-практик зөрөхөд хүргэж байна.

[13]Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем https://www.legalinfo.mn/law/details/120997lawicM2099
[14]https://legalinfo.mn/mn/detail?lawld=11634

3. Сургуулийн нэр өөрчлөгдөх бүрд сургуулийн бэлэг тэмдэг, гадна талбайд байрлуулах нэр, албан бланк, сонсогч, суралцагчдын дүрэмт хувцасны таних тэмдэг, албан хаагчдын үнэмлэх зэргийг өөрчлөх шаардлага гардаг нь жилийн төсөвт суугаагүй тооцоолоогүй зардлыг гаргаж, санхүү эдийн засгийн асуудал үүсгэдэг.

Түүнчлэн Төсвийн тухай хууль тогтоомжоор тухайн жилийн төсөв хуулиар батлагдах үед хуулийн этгээдийн нэрээр батлагдсан байдаг бөгөөд хуулийн этгээдийн нэр өөрчлөгдсөн үед төсвийн мөнгийг зарцуулахад хүндрэл үүсдэг. Гэтэл Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Удирдлагын академи нь өнөөдрийг хүртэл эрх зүйн чадамжтай сургууль Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэдэх Удирдлагын академийн анхны шав тавигдсан түүхэн замнал нь **1924 оны4 дүгээр сарын 5-нд** 18-30 насны 60 залуучуудаас бүрэлдсэн **"Нам, улсын Түр сургууль"-ийг** байгуулснаар эхэлсэн гэж үздэг бөгөөд Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 44 дүгээр тогтоолоор **Удирдлагын академийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэд** байгуулж[15], байсныг энд онцолж дурдах нь зүйтэй.

4. Их сургуулийн нэр, мэргэжлийн индекс, нэршил нь олон солигдох бүрд иргэдийн дунд төөрөгдөл үүсэхээс гадна чухам аль сургуулийг нэрлээд байгаад төдийлөн ойлголт байдаггүй. Цагдаагийн академи, Хууль сахиулахын их сургууль гэсэн нэрээр ойлгож байдаг. Мөн шинээр элсэгчдийн хувьд элсэх сургуулийн нэр, сургалтын хөтөлбөрийн индекс жил бүр өөрчлөгдсөнөөр төөрөгдөл үүсдэг. Их сургуулийн нэршлийн хувьд сонирхолтой баримт сонирхуулаад 2009, 2010 онд элсэгчид суралцах хугацаандаа 3 сургуульд суралцсан байдаг. Тухайн үед тус сургуульд элсэхдээ Цагдаагийн академид, суралцах хугацаандаа Дотоод хэргийн их сургуульд харин төгсөхдөө Хууль сахиулахын их сургуулийг төгссөн байх жишээтэй.

5. Дотоод хэргийн их сургуулийн дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг хэт ойр ойрхон өөрчлөх нь давуу талтай гэхээсээ илүүтэйгээр сул тал ихтэй, их сургуулийн үйл ажиллагаанд нь сөргөөр нөлөөлөх, бодлогын хэрэгжилтэд гажуудал гарах, бэлтгэж буй хүний нөөцийн мэдлэг, чадвар, хандлагад сөргөөр нөлөөлөх, багшийн ажлын ачаалал, механик ажилбар ихсэх, алба хаагч, багш судлаачдын ажилдаа хандах хандлага, идэвх сулрах нөхцөл үүсдэг болох нь асуулгын явцад илэрсэн.

6. Тус Их сургуулийн захирал нь их сургуулийн багш, алба хаагчдыг томилох, чөлөөлөх эрхтэй хэдий ч боловч тэдэнд цагдаагийн цол болон цэргийн цол олгох, дүрэмт хувцас олгох эрх олгогдсон эрх зүйн зохицуулалт байхгүй нь учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл цол олгуулах, цол бууруулах асуудлыг тухайн төв байгууллагын даргад уламжилж шийдвэрлүүлж байгаа нь эрх зүйн чадамжгүй гэж үзэхээр байна. Түүнчлэн тус их сургуулийн багш, албан хаагчид нь цагдаа, хил, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагуудын дүрэмт хувцас, цол хэрэглэж байгаа хэдий ч Цэргийн албаны тухай хууль Цагдаагийн албаны тухай хууль, Монгол Улсын Хилийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх зүйн байдал, нийгэм, эдийн засгийн баталгаагаар

[15]Монгол улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын акамемийн вэб сайтаас http://www.naog.gov.mn/about/history

хандах нь бага бөгөөд тухайн багш, албан хаагчдын эрх зүйн байдал дордсон гэж үзэж болох юм.

7. Дотоод хэргийн их сургуулийн дүрмийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт “Их сургуулийн багш, ажилтан нар нь төрийн тусгай албан хаагч байна” гэж заасан хэдий ч бусад төрийн тусгай байгууллагын албан хаагчийн эрх зүй байдал, нийгэм, эдийн засгийн баталгаатай харилцан адилгүй байгаагаас үүдэн тус их сургуульд ажиллахыг төдийлөн сонирхдоггүй байна. Гэтэл гадаадын улс оронд практик байгууллагад ажиллахаас илүүтэйгээр их, дээд сургуулиудад ажиллах сонирхолтой жишээ олон байдаг байна.

8. Эрүүгийн хуулиар хууль сахиулагч гэж цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчийг ойлгохоор заасан бол Дотоод хэргийн их сургуулийн хувьд хил хамгаалах, онцгой байдлын, шүүхийн шинжилгээний болон дотоод цэргийн албан хаагчид хамаарахгүй гэж ойлгохоор байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2015 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн Галт зэвсгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтад “Хууль сахиулах албаны’’[16] гэж томьёолсон байна.

Бид сүүлийн жилүүдэд төрийн тусгай албаны чиг үүргийг доорх байдлаар нэршлийг өөрөөр тайлбарлан хэрэглэх болжээ. Үүнд:

1 .Төрийн байгууллага;

2 .Хуулийн байгууллага;

3 .Хууль, хяналтын байгууллага;

4 .Хууль, хүчний байгууллага;

5 .Хууль хэрэгжүүлэх байгууллага;

6 .Хууль сахиулах байгууллага;

7 .Хууль зүйн салбарын байгууллага;

8 .Үндэсний аюулгүй байдлыг хангах байгууллага;

9. Хилийн хяналтын байгууллага;

10 .Цэрэг, цагдаагийн байгууллага гэх мэт маш олон нэр томьёогоор тодорхойлж хэрэглэж байгаа нь хуулийг нэг мөр зөв хэрэглэж хэвшээгүйн илрэл юм.

Угтаа бол Улсын Их Хурлын 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн баталсан Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлд “Төрийн албаны ангилал”-ыг дор дурдсанаар тодорхойлсон байдаг. Үүнд:

1 **Төрийн улс төрийн алба**

**2 .Төрийн захиргааны алба**

**3 .Төрийн тусгай алба**

**4 .Төрийн үйлчилгээний алба** гэж тодорхойлжээ. [17]

[16]https://legalinfo.mn/mn/detail?lawId=11270
[17]https://legalinfo.mn/mn/detail?lawId=13025

Тэгвэл бид энэ олон нэр томьёоны тодорхойлолтыг халж гагцхүү хуульд заасан нэр томьёогоор нэрлэж байх нь зүйтэй. Өөрөөр хэлбэл “Төрийн тусгай алба" гэсэн нэрийг хэрэглэх нь зөв юм. Түүнчлэн хуульд төрийн байгууллага гэж томьёолсон байх бөгөөд хууль сахиулах байгууллага гэсэн нэр томьёоны тодорхойлолт байхгүй байна.

Монгол Улсын Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ" гэж заасан.

9. Гадаадын их, дээд сургуулиудын хамтын ажиллагааны хүрээнд тухайн сургуулиудаас манай сургуульд хандахад хүртэл тодорхой хэмжээгээр хүндрэл учирдаг жишээ нэлээдгүй гарсаар байна. Гэтэл гадаадын их, дээд сургуулиуд ойр ойрхон хуулийн этгээдийн нэрээ өөрчлөх тохиолдол төдийлөн ажиглагддаггүй бөгөөд үйл ажиллагаа, статусын хувьд өргөжиж дээд сургуулиас академи, академиас их сургууль болон өөрчлөгддөг зүй тогтолтой.

**Санал**

Дээрх дурдсан үндэслэл, журмыг судалж үзвэл Дотоод хэргийн их сургуулийн эрх зүйн орчин боловсронгуй болгох зорилгоор дараахь саналыг дэвшүүлж байна.

1. Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Дотоод хэргийн их сургуулийн статусыг тодорхой болгож, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болгох;

2. Гадаадын ижил чиг үүрэг бүхий их, дээд сургуулиудын туршлагыг судалж, Дотоод хэргийн их сургуулийн багш, албан хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгаа, чиг үүргийг тодорхойлсон бие даасан хуультай болгох. Ийнхүү Дотоод хэргийн их сургууль бие даасан хуультай болсноороо удирдах албан хаагчийг томилох, чөлөөлөх эрх зүйн зохицуулалт нь тодорхой болохоос гадна багш, албан хаагчдын эрх зүйн болон нийгмийн баталгаа, ажиллах орчин нөхцөл бүрэн хангагдах боломж бүрдэнэ гэж үзэж байна.

3. “Дотоод хэргийн их сургуулийн”хуулийн этгээдийн нэршлийг **“Хууль зүй, дотоод хэргийн их сургууль”** болгон өөрчлөх санал болгож байна. Өөрөөр хэлбэл ДХИС нь бусад суруулиудын нэгэн адил хууль зүйн сургууль бөгөөд төрийн албаны тухай хууль тогтоомжид заасан төрийн тусгай албаны хаагчдыг бэлтгэдэг нь чухал онцлогтой их сургууль юм.

**Эх сурвалжийн жагсаалт**


- Хууль зүй, дотоод хэргийн яамны вэб сайт https://mojha.gov.mn/
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем https://legalinfo.mn/mn/
- Дотоод хэргийн их сургуулийн вэб сайт https://www.uia.gov.mn/

-https://dic.academic.ru/dic.nsf/ruwiki/19903,

-http://vladhistory.com/istoriya-povavleniya-pervyx-shkol/

-http://www.para.by/articles/text/samyi-pervyi-universitet